



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/216.

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд орон нутгийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг Сэлэнгэ аймагт 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдах “Махны үхэр үржүүлэгчдийн туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг”-т оролцуулах, мөн сүү, махны чиглэлийн үхэр, тахианы аж ахуйнуудтай газар дээр нь үзэж танилцах, туршлага судлах ажлын замын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 3,000,000 (гурван сая) төгрөгийг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0403

D:My Doc. Zahiramj. Zasag darga